# БУЛГАН АЙМАГ ДАХЬ
# АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Хангал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/120/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>226 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан.....................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................
   4.2 Материаллаг байдал ......................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ......................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................
5. Аудитын илрүүлэлт ......................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ......................................................


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 261

танай ______ ны № ______ т

ХАНГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ТАМЖИД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хангал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хангал сумын сургууль нь 2025 онд 127 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Боловсролын яамнаас 693.9 мянган төгрөгийн сурах бичиг, орон нутгийн хөгжлийн сангаас 59,800. мянган төгрөгийн бага оврын автобус , 32,419.9 мянган төгрөгийн 15 ширхэг суурин компьютер , 18,000.0 мянган төгрөг гадна төмөр хашааг, 20,000.0 мянган төгрөгийн заалны болон галт тогооны засвар , орон нутгийн иргэдийн хөрөнгө оруулалтаас 17,806 мянган төгрөгийн цахим анги болон хүлээлгийн 4 ширхэг сандал зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор “Цалин хөлс шинэчлэн батлах тухай” төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 01 сарын 23-ны 1/383 албан тоотоор 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн үйл

6326050348

ажиллагааг хангахтай холбоотойгоор 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллахыг чиглэл болгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 5 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай дүгнэгдсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **276,176,105.96** | **299,825,536.79** |
| **31** | **1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **157,935,916.73** | **200,646,101.2** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 157,935,916.73 | 200,646,101.2 |
| 31210 | Төгрөг | 157,935,916.73 | 200,646,101.2 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 157,935,916.73 | 200,646,101.2 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 118,240,189.23 | 95,144422.33 |
| 35100 | Түүхий эд материал | 2,122,520.5 | 0.0 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,115,020.5 | 0.0 |
| 35130 | Эм боох материал | 7,500 | 0.0 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,708,795.5 | 4,528,818.5 |
| 35400 | Хангамжийн материал | 104,113,873.23 | 82,450,603.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 946,300 | 894,700 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,131,215 | 29,644,515 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 250,000 | 0.0 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,281,200 | 2,259,500 |
| 35460 | Хүнсний материал | 15,502,877 | 7,525,074.46 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 51,002,281.23 | 46,161,827.63 |
| 35600 | Мал амьтад | 8,295,000 | 8,165,000 |
| **2** | **1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,110,707,498.04** | **1,109,907,448.48** |
| **39** | **1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,110,707,498.04** | **1,109,907,448.48** |
| 39200 | Биет хөрөнгө | 1,094,069,498.04 | 1,093,269,448.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,656,318,817.59 | 1,676,318,817.59 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,143,368,642.26 | -1,203,198,967.32 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 0.0 | 59,800,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 0.0 | -1,993,333.32 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 224,411,346 | 270,857,765.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -71,880,848.68 | -114,595,895.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 146,963,274.77 | 136,836,754.77 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -107,893,512.36 | -110,416,725.73 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 427,788,056 | 461,394,056 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -42,778,805.52 | -86,242,836.04 |
| 39217 | Ном | 4,509,812.5 | 4,509,812.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 16,638,000 | 16,638,000 |
| 39301 | Програм хангамж | 1,600,000 | 1,600,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,600,000 | -1,600,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,638,000 | 16,638,000 |
| **3** | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **1,386,883,604** | **1,409,732,985.27** |
| **4** | **2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **38,388,642.11** | **14,093,569.49** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **38,388,642.11** | **14,093,569.49** |
| 41300 | Өглөг | 38,388,642.11 | 14,093,569.49 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 7,013,306.51 | 43,112.74 |
| 41360 | Бусад өглөг | 31,375,335.6 | 14,050,456.75 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 31,375,335.6 | 14,050,456.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,218,079.56 | 47,144,453.89 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 435,173,247.93 | 435,173,247.93 |
| **6** | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **1,386,883,604** | **1,409,732,985.27** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **1,226,3414,710.09** | **1,368,021,015.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **42,292,567.5** | **1,368,021,015.72** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 42,292,567.5 | 149,733,953.55 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,291,700 | 1,014,000 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,291,700 | 1,014,000 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 38,835,035 | 148,025,999.95 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,165,832.5 | 693,953.6 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 0.0 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 0.0 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 186,938,515.72 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 1,180,068,500 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,023,464,400 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,023,464,400 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,023,464,400 | 0.0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,225,473,391.53** | **1,516,740,969.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,225,473,391.53** | **1,474,441,515.38** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,206,988,675.23.00 | 1,451,617,575.88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 720,038,106.51 | 909,448,815.71 |
| 210101 | Үндсэн цалин | 443,002,024.31 | 513,734,086.51 |
| 210102 | Нэмэгдэл | 256,508,069.2 | 333,191,555.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 25,185,353.15 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 20,528,013 | 37,337,820.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 80,744,100 | 104,985,478.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 54,918,100 | 70,994,063.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 6,460,900 | 9,180,211.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 3,230,600 | 4,861,232.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 3,230,600 | 3,983,543.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 12,903,900 | 15,966,427.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 153,684,903.59 | 159,338,915.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000 | 8,879,960.68 |
| 210302 | Түлш, халаалт | 145,684,903.59 | 149,058,955.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000 | 1,400,000 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.0 | 16,578,697.7 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.0 | 16,578,697.7 |
| 2105 | Нормативт зардал | 24,519,420.6 | 27,482,367.74 |
| 210502 | Хоол, хүнс | 24,519,420.6 | 27,482,367.74 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,527,228.86 | 26,790,600 |
| 210604 | Урсгал засвар | 25,527,228.86 | 26,790,600 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,825,410.8 | 8,344,758.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,291,700 | 1,014,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,533,710.8 | 7,330,758.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 191,749,904.87 | 198,647,941.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,986,860.16 | 42,604,242.31 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,740,330 | 5,517,750 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 171,022,714.71 | 150,525,949.51 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,484,716.3 | 22,823,939.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,484,716.3 | 22,823,939.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,484,716.3 | 22,823,939.5 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **0.0** | **1,474,441,515.38** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **868,079.56** | **42,299,453.89** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГАА БУС ОРЛОГЫН ДҮН** | **3,225,000** | **4,845,000** |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 3,225,000 | 4,845,000 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,875,000 | 0 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 1,875,000 | 0 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | **1,350,000** | **4,845,000** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **2,218,079.56** | **47,144,453.89** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|---|
| **1** | **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,024,756,100** | **1,368,021,015.72** |
| **2** | **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,291,700** | **1,368,021,015.72** |
| 3 | 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,291,700 | 1,014,000 |
| 4 | 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,291,700 | 1,014,000 |
| 5 | 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,291,700 | 1,014,000 |
| 6 | 122 | Тусламжийн орлого | 0.0 | 1,180,068,500 |
| 7 | 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 1,180,068,500 |
| 8 | 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 1,180,068,500 |
| 9 | 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 1,180,068,500 |
|  | 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 186,938,515.72 |
| 10 | 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,023,464,400 | 0.0 |
| 11 | 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,023,464,400 | 0.0 |
| 12 | 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,023,464,400 | 0.0 |
| **13** | **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **868,047,750.06** | **1,323,610,931.25** |
| **14** | **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **868,047,750.06** | **1,323,610,931.25** |
| **15** | **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **849,542,851.06** | **1,299,966,968.75** |
| 16 | 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 713,024,800 | 916,462,122.22 |
| 17 | 210101 | Үндсэн цалин | 435,988,717.8 | 520,747,393.02 |
| 18 | 210102 | Нэмэгдэл | 256,508,069.2 | 333,191,555.28 |
| 19 | 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 25,185,353.15 |
| 20 | 210104 | Урамшуулал | 20,528,013 | 37,337,820.77 |
| 21 | 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 80,744,100 | 104,942,365.65 |
| 22 | 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 54,918,100 | 70,950,951.13 |
| 23 | 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 6,460,900 | 9,180,211.04 |
| 24 | 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 3,230,600 | 4,861,232.36 |
| 25 | 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 3,230,600 | 3,983,543.62 |
| 26 | 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 12,903,900 | 15,966,427.5 |
| 27 | 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 153,684,903.59 | 159,338,915.72 |
| 28 | 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000 | 8,879,960.68 |
| 29 | 210302 | Түлш, халаалт | 145,684,903.59 | 149,058,955.04 |
| 30 | 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000 | 1,400,000 |
| 31 | 2105 | Нормативт зардал | 31,650,370 | 19,504,565.2 |
| 32 | 210502 | Хоол, хүнс | 31,650,370 | 19,504,565.2 |
| 33 | 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,899,600 | 27,599,600 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 34 | 210604 | Урсгал засвар | 6,899,600 | 27,599,600 |
| 35 | 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,825,410.8 | 11,344,758.8 |
| 36 | 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,291,700 | 1,014,000 |
| 37 | 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,533,710.8 | 10,330,758.8 |
| 38 | 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,298,170.26 | 60,774,641.16 |
| 39 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,744,670.26 | 56,909,141.16 |
| 40 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,553,500 | 3,865,500 |
| 41 | 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,504,899 | 23,643,962.5 |
| 42 | 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,504,899 | 23,643,962.5 |
| 43 | 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,504,899 | 23,643,962.5 |
| **44** | **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **156,708,349.94** | **44,410,084.47** |
| **45** | **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **45,558,673.4** | **1,699,900** |
| 46 | 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 45,558,673.4 | 1,699,900 |
| 47 | 2200 | Дотоод эх үүсвэрээр | 45,558,673.4 | 1,699,900 |
| 48 | 222001 | Тоног төхөөрөмж | 0.0 | 1,699,900 |
| 49 | 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 45,558,673.4 | 0 |
| **50** | **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-45,558,673.4** | **-1,699,900** |
| **51** | **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **111,149,676.54** | **42,710,184.47** |
| 52 | 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 46,786,240.19 | 157,935,916.73 |
| 53 | 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 157,935,916.73 | 200,646,101.2 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **435,173,247.93** | **702,815,488.74** | **1,346,276,882.33** |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 208,288,145.66 | 435,173,247.93 | 702,815,488.74 | 1,346,276,882.33 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 2,218,079.56 | 2,218,079.56 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **435,173,247.93** | **705,033,568.3** | **1,348,494,961.89** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **435,173,247.93** | **705,033,568.3** | **1,348,494,961.89** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 208,288,145.66 | 435,173,247.93 | 705,033,568.3 | 1,348,494,961.89 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 47,144,453.89 | 47,144,453.89 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **208,288,145.66** | **435,173,247.93** | **752,178,022.19** | **1,395,639,415.78** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,437,409,400 | 1,181,082,500 |
| 12 | Татварын бус орлого | 1,437,409,400 | 1,181,082,500 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,207,400 | 1,014,000 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 1,014,000 | 1,014,000 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 26,193,400 | 0.0 |
| 122 | Тусламжийн орлого | 1,195,185,900 | 1,180,068,500 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,195,185,900 | 1,180,068,500 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 215,016,100 | 186,938,515.72 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,382,913,615.72 | 1,138,372,315.53 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,519,506,715.72 | 1,138,372,315.53 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,519,506,715.72 | 1,114,728,353.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,092,620,500 | 916,462,122.22 |
| 210101 | Үндсэн цалин | 655,884,000 | 520,747,393.02 |
| 210102 | Нэмэгдэл | 401,947,500 | 333,191,555.28 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 25,185,353.15 |
| 210104 | Урамшуулал | 34,789,000 | 37,337,820.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 136,577,400 | 104,942,365.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,872,700 | 70,950,951.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,926,200 | 9,180,211.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,463,000 | 4,861,232.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,463,000 | 3,983,543.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,852,500 | 15,966,427.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 182,656,000 | 159,338,915.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,000,000 | 8,879,960.68 |
| 210302 | Түлш, халаалт | 168,856,000 | 149,058,955.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000 | 1,400,000 |
| 2105 | Нормативт зардал | 46,452,100 | 19,504,565.2 |
| 210502 | Хоол, хүнс | 46,452,100 | 19,504,565.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,360,100 | 27,599,600 |
| 210604 | Урсгал засвар | 32,360,100 | 27,599,600 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,606,900 | 11,344,758.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,014,000 | 1,014,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,592,900 | 10,330,758.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,844,400 | 62,474,541.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,832,900 | 58,609,041.16 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,011,500 | 3,865,500 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,597,500 | 23,643,962.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 29,597,500 | 23,643,962.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,597,500 | 23,643,962.5 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -157,305,500 | 42,710,184.47 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 157,305,500 | -42,710,184.47 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 157,305,500 | -42,710,184.47 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 157,935,916.73 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 200,646,101.2 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,188.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил[1] илэрснээс 15,900.0 мянган төгрөгийн залруулах алдаа нэг, 6,019.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 14,705.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9,563.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн зөрчлүүд нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба тоо хэмжээ их ч санхүүгийн тайланд нөлөөлөх магадлал бага цаашид засах зөрчил тул материаллаг багатай гэж үзэн өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

**Залруулах алдаа :**

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 15,900.0 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг, аж ахуйн материал, хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн зардалд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5".батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" зөрчигдсөн байна.

**5.1 Төлбөрийн акт**

- *Илрүүлэлт:* Гамшигаас хамгаалах штабын сургалтад оролцсон ажилчдад сургуулийн захирлын 2025 оны 04 сарын 17-ний өдрийн Б/18 тоот тушаалаар 4 ажилтанд 619.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- *Илрүүлэлт:* Томилолтоор ажилласан ажилчдын хоолны мөнгийг давхар тооцон 200.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.2.3. хоолны зардал" олгогддог байхад давхардуулж олгосон байна.
- *Илрүүлэлт:* Малын данснаас зарлагадан зарж борлуулсан 13 ямааны орлого 910.0 мянган төгрөг, ямааны 33 кг ноолуур зарж борлуулсан 4,290.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайлан балансад тусгахгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14 дүгээр зүйлийн 14.4.5 “бүх орлого”, Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан " Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 2.28, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6."хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх" 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг зөрчсөн.

### 5.2 Албан шаардлага

- *Илрүүлэлт:* Тус сургуулийн захирал хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 654.8 мянган төгрөгийн цалин авсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2. "Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна". 27 дугаар зүйлийн 27.4."Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна" гэсэн заалт зөрчигдсөн байна.
- *Илрүүлэлт:* Моби нет төхөөрөмжийг зээлээр худалдан авах гэрээг хийн худалдан авсан тушаал шийдвэр байхгүй, цахим дэлгүүрт байхгүй компаниас худалдан авалт хийж тухайн жилд төлөх төлбөрийг төлж 14,050.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2."Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна".Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.6.2."төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтууд зөрчигдсөн байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Тайлагналтай холбоотой.**

*Илрүүлэлт:* Тайлангийн хугацаанд тус байгууллагын нягтлан бодогч солигдсон боловч ажил хүлээлцээгүй, тооллого тооцоо хийж хөрөнгө, өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй, ажил хүлээлцсэн акт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.2 ".эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой.**

Илрүүлэлт: Улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд сургуулийн эзэмшилд 1,398.0 мянган төгрөгийн үнэлгээтэй 699 м.кв газар эзэмших эрх байгаа боловч Санхүүгийн тайланд тусгагдаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 "үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4."үнэн зөв байх", Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**3. Бараа материалын данстай холбоотой.**

Илрүүлэлт: Мал амьтдын дансанд хонь 60.0 мянган төгрөг, ямаа 60.0 мянган төгрөг, ишиг хурга 20.0 мянган төгрөг, үхэр 255.0 мянган төгрөгийн үнэлгээтэй нийт 8,165.0 мянган төгрөгийн мал байгаа нь зах зээлийн үнээс доогуур үнэлгээтэй бүртгэлд тусгагдсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4".үнэн зөв байх", 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1 хавсралтын 12.8, 12.9, 12.10 зэрэг заалтууд зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зардал гүйлгэн зарцуулсан | 1 | 15,900.0 | | | 1 | 15,900.0 | 1 | 15,900.0 | | | | |
| **Нийт дүн** | **1** | **15,900.0** | | | **1** | **15,900.0** | **1** | **15,900.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өөрийн орлого бүртгэлд тусгаагүй зарцуулсан | 1 | 5,200.0 | 1 | 5,200.0 | | | | | | | | |
| Томилолтоор ажилласан ажилтанд хоолны мөнгө давхардуулан олгосон | 1 | 200.0 | 1 | 200.0 | | | | | | | | |
| Үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон. | 1 | 619.9 | 1 | 619.9 | | | | | | | | |
| Ажил хавсран гүйцэтгэсэн байна. | 1 | 654.8 | | | 1 | 654.8 | | | | | | |
| Өглөгийн дансны үлдэгдэлтэй | 1 | 14,050.4 | | | 1 | 14,050.4 | | | | | | |
| Бүртгэлийн ажилтан ажил солилцоход тооллого хийгээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй | 1 | 1,398.0 | | | | | 1 | 1,398.0 | | | | |
| Мал амьтдын бүртгэлийн үнэлгээ | 1 | 8,165.0 | | | | | 1 | 8,165.0 | | | | |
| **Дүн** | **8** | **30,288.1** | **3** | **6,019.9** | **2** | **14,705.2** | **3** | **9,563.3** | | | | |